



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/615

Улаанбаатар хот

“Баянгол дүүргийн “Баянгол Шинэ өргөө” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл”-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 92,070,000.00 (ерэн хоёр сая далан мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянгол дүүргийн “Баянгол Шинэ өргөө” ОНӨААТҮГ (Б.Түвшинтөр)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн “Баянгол Шинэ өргөө” ОНӨААТҮГ (Б.Түвшинтөр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



Энгийн Өмчийн харилцааны газар
2024 оны 12 дугаар сарын 19-ны
А/б.3 дугаар тушаалын хавс

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн "Баянгол Шинэ өргөө" ОНӨААТҮГ

Нийт бүртгэх хөрөнгийн дүн